



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 28 өдөр

Дугаар

A/53

Улаанбаатар хот

2018-2019 оны хичээлийн жилийн бакалаврын  
элсэлтийн журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 12 дугаар зүйлийн 12.1.6, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/79 дүгээр тушаал, Хууль сахиулахын их сургуулийн дүрмийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 12.2-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хууль сахиулахын их сургуулийн “2018-2019 оны хичээлийн жилийн бакалаврын элсэлтийн шалгалтын журам”-ыг нэгдүгээр, элсүүлэх хөтөлбөр, элсэлтийн ерөнхий шалгалтын босго оноо, хяналтын тоог хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Элсэлтийн журмыг нийтэд сурталчлах, мэдээлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Сургалт, чанарын алба, Соёл, олон нийттэй харилцах албаны дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Энхболд/ нарт тус тус үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт эрхэлсэн дэд захирал /цагдаагийн хурандаа Д.Эрдэнэбаатар/-д даалгасугай.

ЗАХИРАЛ, ПРОФЕССОР,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Ө.ЭНХТӨР

ХУУЛБАР ҮНЭН  
ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА П.ОРОСТОГОО





## 2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН БАКАЛАВРЫН ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Хууль сахиулахын их сургууль /цаашид “Их сургууль” гэх/-ийн 2018-2019 оны хичээлийн жилийн бакалаврын элсэлтийн шалгалтыг зохион байгуулахтай холбогдох харилцааг зохицуулна.

1.2. Элсэлтийн шалгалтыг зохион байгуулахад Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/79, 2014 оны А/143, 2016 оны А/87 дугаар тушаал, Хууль зүйн сайдын 2015 оны А/148, 2016 оны А/146 дугаар тушаал болон энэ журмыг баримтална.

1.3. Их сургууль нь 2018-2019 оны хичээлийн жилд элсэлт авах бакалаврын хөтөлбөр, шалгалтын чиглэл, босго оноо, элсүүлэх хяналтын тоог захиалагч агентлаг, байгууллагын саналыг харгалзан энэ журмын хавсралтаар тогтооно.

1.4. Элсэлтийн шалгалтын үйл ажиллагааг Нийслэлийн Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо, Хилчний гудамж /бүсчлэлийн код 13260/-д байрлах Их сургуулийн байранд /цаашид Их сургуулийн байрлал гэх/ зохион байгуулна.

1.5. Элсэлтийн шалгалттай холбогдох мэдээллийг Их сургуулийн “[www.leu.gov.mn](http://www.leu.gov.mn)” цахим хуудсанд байршуулж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

1.6. Элсэлтийн шалгалтад элсэгчийн төлөөлөл болон бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтан хууль тогтоомжийн хүрээнд хөндлөнгийн хяналт тавина.

1.7. Чансааны оноог суурь 1, хавсарга 2 шалгалт, нийт 3 шалгалтын нийлбэрээр тогтооно.

### Хоёр. Суралцагч элсүүлэх үе шат

2.1. Их сургууль өдрийн ангид суралцагч элсүүлэх ажлыг дараах үе шаттай зохион байгуулна:

№	Үе шат	Эхлэх, дуусах хугацаа	Байрлал	Нэмэлт тайлбар
1	Цахим бүртгэл	2018-04-02.08.00' 2018-06-15.17.00'	<a href="http://www.leu.gov.mn">www.leu.gov.mn</a>	Зөвхөн интернет /цахим/-ээр явагдах бөгөөд аймаг, орон нутагт тусгайлсан бүртгэл явагдахгүй.
2	Ял шийтгэгдэж байсан эсэхийг шалгах	2018-04-30- 2018-06-30	<a href="http://www.leu.gov.mn">www.leu.gov.mn</a>	Энэ журмын 3.2.4-ийг үзнэ үү.
3	Элсэлтийн ерөнхий шалгалтын оноогоор эрэмбэлсэн жагсаалт гаргах	2018-07-01. 14.00'	<a href="http://www.leu.gov.mn">www.leu.gov.mn</a>	Хяналтын тоо +30%-д багтсан иргэнд нэмэлт шалгалтад орох эрх үүснэ. Дэлгэрэнгүй мэдээллийг энэ журмын 5.6, 5.7-оос үзнэ үү.
4	Шалгалтын хуудас олгох	2018-07-02- 2018-07-03. 09.00'-17.00'	Их сургуулийн байранд	Шалгалтын хуудас олгоход бүрдүүлэх материалын талаар энэ журмын 5.9, 5.10-аас үзнэ үү.

5	Нэмэлт шалгалт-1	2018-07-04-2018-07-09.08.00'-17.00'	Их сургуулийн байранд	-Эрүүл мэнд; -Бие бялдар; Журмын 6.1, 6.2-ыг үзнэ үү.
6	Цэргийн хэргийн анхан шатны бэлтгэл сургалт	2018-07-20 2018-08-25	Их сургуулийн сургалт дадлагын төв	Энэхүү бэлтгэл сургалтын үед нэмэлт шалгалт-2-т хамрагдана.
7	Нэмэлт шалгалт-2	2018-07-10-2018-08-25	Их сургуулийн сургалт дадлагын төв	-Монгол хэлбичгийн ур чадварын шалгалт; -Сэтгэл зүйн сорил, Ярилцлага; -Захиалагч агентлаг, байгууллагын зан байдал, төлөвшил, ёс зүй, гэмт хэрэг, зөрчлийн холбогдол шалгах судалгаа; Дэлгэрэнгүй мэдээллийг энэ журмын 7.6-аас үзнэ үү.
8	Элсүүлэн суралцуулах	2018-08-25, 2018-09-01	ХСИС	Их сургуулийн захирлын тушаалаар элсүүлэн суралцуулна.

2.2. Их сургууль урьд нь дээд боловсрол эзэмшсэн иргэнийг элсүүлэх ажлыг дараах үе шаттай зохион байгуулна:

№	Үе шат	Эхлэх, дуусах хугацаа	Байрлал	Нэмэлт тайлбар
1	Бүртгэх	2018-06-04-2018-06-23.14.00'-16.00'	Их сургуулийн байр	"Цагдаа-хууль сахиулах ажил" 2 жил; "Шинжээч-мөрдөгч" 2 жил;
2	Нэмэлт шалгалт	2018-07-04-2018-09.01	Их сургуулийн байр, Сургалт, дадлагын төв	Энэ журмын 2 дугаар зүйлийн 2.1-ийн 5-7 дугаар үе шатад заасан нэмэлт шалгалтуудыг өгнө.

2.3. Их сургууль эчнээ сургалтад албан хаагчийг элсүүлэх ажлыг дараах үе шаттай зохион байгуулна:

№	Үе шат	Эхлэх, дуусах хугацаа	Байрлал	Нэмэлт тайлбар
1	Захиалагчаас элсэгчийг суралцуулахыг дэмжсэн албан бичиг, нэрсийн жагсаалт, бакалаврын дипломын хуулбар, холбогдох бусад судалгаа, материалыг хүлээн авах	2018-05-01-ний дотор	Их сургуулийн байр	3 жилийн эчнээ сургалт
2	ОБЕГ-аас элсэгчийг суралцуулахыг дэмжсэн албан бичиг, нэрсийн жагсаалт, бакалаврын дипломын хуулбар, холбогдох бусад судалгаа, материалыг хүлээн авах	2018-04-02-ны дотор	Их сургуулийн байр	"Онцгой байдал-гамшгаас хамгаалах" бакалаврын хөтөлбөрийн 1.5 жилийн сургалт
3.	Захиалагчаас элсэгчийн нэрс, элсэлтийн ерөнхий шалгалтын батламжийн хуулбар, холбогдох бусад материалыг хүлээн авах	2018-07-03-ны дотор	Их сургуулийн байр	5 жилийн эчнээ сургалт

2.4. Энэ журмын 2.2, 2.3 дахь хэсэгт заасан иргэн болон албан хаагч цахим бүртгэлд бүртгүүлэхгүй.

### Гурав. Элсэгчид тавих шаардлага

3.1. Элсэгч дараах нийтлэг шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн байна.

3.1.1. бүрэн дунд болон мэргэжлийн боловсролтой элсэгч нь 2016 оноос хойш элсэлтийн ерөнхий шалгалтын монгол хэлбичгийн шалгалтыг заавал өгсөн байх;

3.1.2. сонгосон хөтөлбөрт хамаарах хичээлүүдийн элсэлтийн ерөнхий шалгалтын оноо нь энэ журмын хавсралтаар тогтоосон босго онооноос багагүй байх;

3.1.3. элсэлтийн ерөнхий шалгалтын батламж хүчинтэй байх;

3.1.4. дээд боловсролтой элсэгчийн бакалаврын диплом хүчинтэй, сурлагын голч дүн 2.6-аас доошгүй байх;

3.2. Элсэгч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна:

3.2.1. эрэгтэй, 17-25 хүртэл насны, биеийн өндөр 170 см буюу түүнээс дээш, “Аюулгүй байдал-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага” ангид элсэгч 173 см буюу түүнээс дээш;

3.2.2. эмэгтэй, 17-20 хүртэл насны, биеийн өндөр 165 см буюу түүнээс дээш;

3.2.3. нэмэлт шалгалт /эрүүл мэнд, бие бялдар, монгол хэлбичиг, сэтгэл зүйн сорил, ярилцлага/-д тэнцсэн байх;

3.2.4. ял шийтгэлгүй, захиалагч агентлаг, байгууллагын холбогдох судалгаанд тэнцсэн байх;

3.2.5. “Эрх зүй” хөтөлбөрт элсэгч нь сэтгэл зүйн сорил, ярилцлагад тэнцсэн байх;

### Дөрөв. Элсэлтийн нэмэлт шалгалт

4.1. Өдрийн сургалтад элсэгч иргэдээс дараах нэмэлт шалгалт авна:

№	Нэмэлт шалгалтын чиглэл	Шалгуур	Зохион байгуулах хугацаа	Зохион байгуулах газар
1	Эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийн ерөнхий шалгуур	-Эрүүл мэндийн хувьд цэргийн албанд тэнцэх (Батлан хамгаалах, Хууль зүй, Эрүүл мэнд, спортын сайдын хамтарсан 2016 оны А/115, А/174, А/194 дугаар тушаал) -шивээсгүй; -бие эрхтний зөв хөгжилтэй, биеийн ил харагдах хэсэгт 20x05мм-ээс том сорвигүй байх; -мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралгүй байх;	2018.07.04- 2018.07.06 08.00-17.00 цаг	Их сургуулийн байрлалд
2	Бие бялдрын шалгалт	Хүч, тэсвэр, уян хатан, хурд, авхаалж самбаа гэсэн 5 чанар тус бүрээр зохих шалгуур хангасан байх;	2018.07.07- 2018.07.09 08.00-17.00 цаг	Их сургуулийн байрлалд
4	Сэтгэл зүйн сорил, ярилцлага	“Эрх зүй” хөтөлбөрт элсэгч Сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэн бодох чадвар, мэргэжлийн сонголт хийж буй сэтгэл зүйн хандлагын түвшин;	2018.08.25- 09.00 цаг	Их сургуулийн байрлалд

	“Эрх зүй”-ээс бусад хөтөлбөрт элсэгч	2018.07.10-2018.08.20	Цэргийн хэргийн бэлтгэл сургалтын явцад	
5	Монгол хэлбичгийн ур чадварын шалгалт	Эсээ бичих; Өөрийн санааг баримтад тулгуурлан зөв бичгийн болон хэл зүй, өгүүлбэр зүй, найруулга зүйн шалгуур, шаардлагыг ханган илэрхийлсэн байх;	2018.07.10-2018.08.20	Цэргийн хэргийн бэлтгэл сургалтын явцад
6	Ёс зүй, бие хүний хандлагын төлөвшил	Захиалагч агентлаг, байгууллагын зан байдал, хандлага, ёс зүй, гэмт хэрэг, зөрчлийн холбогдол шалгах судалгаанд тэнцсэн байх;	2018.07.10-2018.08.20	Цэргийн хэргийн бэлтгэл сургалтын явцад
7	Цэргийн хэргийн анхан шатны бэлтгэл сургалт	Цэргийн хэргийн анхан шатны бэлтгэл сургалтад тэнцсэн байх;	2018.07.20-2018.08.25	Гүнжийн хоолой дахь сургалт, дадлагын төв

### Тав.Элсэлтийн зохион байгуулах журам

5.1. Цахим бүртгэлд бүртгүүлэхдээ элсүүлэх хөтөлбөрүүдээс зөвхөн нэг хөтөлбөрийг сонгож, зааврын дагуу хувийн мэдээллээ бүрэн, зөв оруулж баталгаажуулна. Бүртгэлийн мэдээллийг бүрэн бус, дутуу оруулсан, 2 буюу түүнээс дээш хөтөлбөр сонгосон тохиолдолд хүчингүйд тооцож элсэгчээр бүртгэхгүй.

5.2. “Цагдаа-хууль сахиулах ажил” хөтөлбөрийн 2 жил, “Шинжээч-мөрдөгч” 2 жилийн сургалтад элсэгч дээд боловсролтой иргэн дараах баримт бичгийг бүрдүүлэн Их сургуулийн байрлалд биечлэн ирж бүртгүүлнэ:

- 5.2.1. иргэний үнэмлэхийн хуулбар эсхүл лавлагаа;
- 5.2.2. төрийн албан хаагчийн анкет; /маягт 1/
- 5.2.3. бакалаврын диплом, хавсралтын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- 5.2.4. цээж зураг - 3x4 хэмжээтэй 4 хувь;

5.3. Захиалагч агентлаг, байгууллагын алба хаагч хүсэлтээ харьяалах байгууллагаараа уламжлуулан ирүүлнэ. Харьяалах байгууллагын хүний нөөц, сургалтын асуудал эрхэлсэн нэгжээс суралцуулах зөвшөөрөл өгөөгүй алба хаагчийг бүртгэхгүй.

5.4. Цахим бүртгэлд бүртгүүлсэн иргэн урьд ял шийтгэгдэж байсан бол бүртгэлээс хасна.

5.5. Их сургуулийн элсэлтийн цахим бүртгэлд бүртгүүлсэн иргэдийг хөтөлбөр тус бүрээр элсэлтийн ерөнхий шалгалтын суурь болон хавсарга шалгалтуудын онооны нийлбэрээр буурах эрэмбээр жагсааж, хяналтын тоог 30 хүртэл хувиар нэмэгдүүлсэнтэй тэнцэх тооны иргэдэд нэмэлт шалгалт, судалгаанд хамрагдах эрх олгоно. (Жишээлбэл, хяналтын тоо 100 байх тохиолдолд элсэгчдийн жагсаалтын эхний 130-д багтсан иргэн нэмэлт шалгалтад орно.)

5.6. Нэмэлт шалгалтад хамрагдах эрх үүссэн элсэгчийн нэрсийн жагсаалтыг Их сургуулийн цахим хуудсаар нийтэд, бүртгүүлсэн цахим хаяг, гар утсаар элсэхийг хүсэгчид мэдэгдэнэ.

5.7. Элсэлтийн ерөнхий шалгалтын босго оноог хангасан боловч чансааны оноогоор нэмэлт шалгалтад орох эрх бүхий элсэгчийн жагсаалтад багтаагүй элсэгчийг бүртгэлээс хасах ба нэмэлт шалгалтад оруулахгүй.

5.8. “Цагдаа-хууль сахиулах ажил” хөтөлбөрийн 2 жил, “Шинжээч-мөрдөгч” 2 жилийн сургалтад элсэгч дээд боловсролтой иргэдийн бакалаврын сургалтын голч

дүнгээр эрэмбэлсэн чансааны жагсаалт, холбогдох мэдээллийг энэ журмын 5 дугаар зүйлийн 5.6-д заасны дагуу мэдээлнэ.

5.9. Нэмэлт шалгалтад орох эрх үүссэн элсэгчид шалгалтын хуудас олгоно. Шалгалтын хуудсыг улсын хэмжээнд зөвхөн Их сургуулийн байрлалд олгох бөгөөд аймаг, орон нутагт олгохгүй.

5.10. Шалгалтын хуудсыг дараах баримт бичгийг бүрдүүлж биечлэн ирсэн элсэгчид олгоно:

5.10.1. иргэний үнэмлэхийн хуулбар эсхүл лавлагаа;

5.10.2. бүрэн дунд боловсролын гэрчилгээний хуулбар;

5.10.3. дээд боловсролтой иргэний хувьд бакалаврын диплом, хавсралтын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

5.10.4. элсэлтийн ерөнхий шалгалтын батламж /2018 онд элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн бол батламжийн эх хувийг шаардахгүй/;

5.10.5. цээж зураг - 3x4 хэмжээтэй 4 хувь;

5.11. Эрүүл мэнд, бие бялдрын нэмэлт шалгалтад тэнцсэн элсэгчдийг элсэлтийн ерөнхий шалгалтын чансааны оноогоор буурах эрэмбээр жагсаан, хяналтын тоонд багтсан иргэдийг Их сургуулийн элсэлтийн мэдээллийн самбар болон цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.

5.12. Агентлаг, байгууллагын захиалгаар сонгон шалгаруулалтгүй буюу хөнгөлттэй нөхцөлөөр элсэх алба хаагч, иргэний хувьд элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн нэг хичээлийн босго оноо боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан тухайн жилийн босго оноог хангасан байна.

5.13. Агентлаг, байгууллагын захиалгаар “Цагдаа-хууль сахиулах ажил”, “Шалган нэвтрүүлэх алба-хууль сахиулах ажил”, “Аюулгүй байдал-дотоодын цэрэг”, “Сэтгэл судлал” хөтөлбөрүүдэд хүйсийн зохист харьцааг харгалзан эмэгтэй элсэгч элсүүлж болно.

### **Зургаа. Нэмэлт шалгалт зохион байгуулах**

6.1. “Эрх зүй” хөтөлбөрөөс бусад хөтөлбөрт элсэгчийн “Эрүүл мэндийн үзлэг”-ийг Их сургуулийн байрлалд Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгийн нарийн мэргэжлийн эмч нарын бүрэлдэхүүнтэй баг зохион байгуулна.

6.2. Эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн элсэгчийг бие бялдрын нэмэлт шалгалтад хамруулна. Бие бялдрын шалгалтыг дараах шалгуураар үнэлнэ.

### **Эрэгтэй**

д/д	Хүч	Тэсвэр	Хурд	Авхаалж самбаа	Уян хатан	Оноо
	Гар дээр суниалт	1000м	100м	Цогцолбор дасгал	Сууж урагш бөхийх	
1.	62	3.15	14.00	115	65	20.
2.	60	3.20	14.10	114	64	19
3.	58	3.25	14.20	113	63	18
4.	56	3.30	14.30	112	62	17
5.	54	3.35	14.40	111	61	16
6.	52	3.40	14.50	110	60	15
7.	50	3.45	14.60	109	59	14
8.	48	3.50	14.70	108	58	13
9.	46	3.55	14.80	107	57	12
10.	44	4.00	14.90	106	56	11

11.	42	4.05	15.00	105	55	10
12.	40	4.10	15.10	104	54	9
13.	39	4.15	15.20	103	53	8
14.	38	4.20	15.30	102	52	7
15.	37	4.25	15.40	101	51	6
16.	36	4.30	15.50	100	50	5
17.	35	4.35	15.60	99	49	4
18.	34	4.40	15.70	98	48	3
19.	33	4.45	15.80	97	47	2
20.	32	4.50	15.90	96	46	1

Эмэгтэй

д/д	Хүч	Тэсвэр	Хурд	Авхаалж самбаа	Уян хатан	Оноо
	Гар дээр суниалт	1000м	100м	Цогцолбор дасгал	Сууж урагш бөхийх	
1.	40	3.50	15.00	90	65	20
2.	38	3.55	15.10	89	64	19
3.	36	3.60	15.20	88	63	18
4.	34	4.00	15.30	87	62	17
5.	32	4.05	15.40	86	61	16
6.	30	4.10	15.50	85	60	15
7.	28	4.15	15.60	84	59	14
8.	26	4.20	15.70	83	58	13
9.	24	4.25	15.80	82	57	12
10.	22	4.30	15.90	81	56	11
11.	18	4.35	16.00	80	55	10
12.	16	4.40	16.10	79	54	9
13.	14	4.45	16.20	78	53	8
14.	12	4.50	16.30	77	52	7
15.	10	4.55	16.40	76	51	6
16.	8	4.60	16.50	75	50	5
17.	6	5.00	16.60	74	49	4
18.	4	5.05	16,70	73	48	3
19.	2	5.10	16,80	72	47	2
20.	1	5.15	16,90	71	46	1

6.3. Бие бялдрын шалгалтын 5 чанарын авбал зохих 100 онооноос чанар тус бүрт 10 буюу түүнээс дээш, нийлбэр дүнгээр 50 буюу түүнээс дээш оноо, “Хилийн алба-тусгай бэлтгэл” хөтөлбөрт элсэгч бие бялдрын нэмэлт шалгалтын шалгуур үзүүлэлтийн 5 чанар тус бүрт 15 буюу түүнээс дээш оноо авсан тохиолдолд тэнцэнэ. Бие бялдрын шалгалтад тэнцээгүй элсэгчийг бүртгэлээс хасч, дараагийн нэмэлт шалгалтад оруулахгүй.

6.4. Бие бялдрын шалгалтын оноо элсэгчийн чансааны эрэмбэд нөлөөлөхгүй.

6.5. Их сургуулийн чансааны оноог хангаж, нэмэлт шалгалтад орох тухай мэдээлэл хүлээн авсан “Эрх зүй” хөтөлбөрт элсэгч 2018 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 09.00 цагт Их сургуулийн байрлалд биеэр ирж бүртгүүлэн шалгалтын хуудас авна.

6.6. Шалгалтын хуудас бүхий “Эрх зүй” хөтөлбөрт элсэгч 2018 оны 08 дугаар сарын 25-ны 09.00 цагт сэтгэл зүйн сорил, ярилцлагад орно.

6.7. Сэтгэл зүйн сорил ярилцлагад 70 буюу түүнээс дээш хувиар тэнцэх ба чансааны эрэмбэд нөлөөлөхгүй.

6.8. “Эрх зүй” хөтөлбөрийн нэмэлт шалгалтад тэнцсэн элсэгч энэ журмын 7.3-д заасан баримт бичгийг бүрдүүлэн 2018 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 09.00 цагт Их сургуулийн байрлалд биеэр ирж, бүртгэлээ баталгаажуулна.

### **Долоо.Цэргийн хэргийн бэлтгэл**

7.1. Хяналтын тоонд багтсан элсэгч цэргийн хэргийн бэлтгэл сургалтад хамрагдана.

7.2. Цэргийн хэргийн бэлтгэл сургалтыг Их сургуулийн Сургалт, дадлагын төвд 2018 оны 08 дугаар сарын 25-ны дотор багтаан 4-өөс доошгүй долоо хоногийн хугацаатай зохион байгуулна.

7.3. Цэргийн хэргийн бэлтгэл сургалтад хамрагдах элсэгчид дараах баримт бичгийг бүрдүүлэн 2018 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 09.00 цагт Их сургуулийн байрлалд биеэр ирж бүртгүүлнэ.

7.3.1. иргэний үнэмлэх;

7.3.2. эрүүл мэндийн даатгалын дэвтэр /2018 оны 09 дүгээр сар хүртэл хугацааны даатгалыг бүрэн төлсөн байх/;

7.3.3. гэнэтийн ослын даатгалд даатгуулах хураамж;

7.4. Цэргийн хэргийн бэлтгэл сургалтад суралцахтай холбогдон гарах зардлыг элсэгч хариуцан төлнө. Сургалтын явцад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сургалтыг орхисон, сахилгын зөрчил гаргасан, Сургалтын төвийн даргын зөвшөөрөлгүй байрлалыг орхин явсан элсэгчийг бүртгэлээс хасах ба элсүүлэн суралцуулахгүй. Энэ тохиолдолд бэлтгэл сургалтын төлбөрийг буцаан олгохгүй.

7.5. Эрүүл мэндийн болон бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар бүртгэлээс хасагдсан элсэгчийн бэлтгэл сургалтад хамрагдсан хугацааны зардлыг суутган, үлдэгдэл төлбөрийг буцаан олгоно.

7.6. Элсэлтийн комисс цэргийн хэргийн бэлтгэл сургалтад хамрагдаж байгаа элсэгчдээс монгол хэлбичгийн ур чадварын нэмэлт шалгалт болон сэтгэл зүй, зан байдал, төлөвшил, ёс зүй, гэмт хэрэг, зөрчлийн судалгааг 2018 оны 08 дугаар сарын 20-ны дотор зохион байгуулна.

7.7. Захиалагч байгууллагын судалгаагаар элсэгчид тавих тусгай шалгуурыг хангаагүй гэж дүгнэсэн элсэгчийг бүртгэлээс хасах ба элсүүлэн суралцуулахгүй.

### **Найм. Захиалагч агентлаг, байгууллагын алба хаагчдын элсэлтийн шалгалтын зохион байгуулалт**

8.1. Захиалагч агентлаг, байгууллагаас суралцахыг дэмжсэн бакалаврын хөтөлбөрийн 3 жилийн эчнээ сургалтад элсэгч дээд боловсролтой алба хаагчдын элсэлтийн шалгалтыг 2018 оны 06 дугаар сарын 04-нөөс 06 дугаар сарын 08-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулна.

8.2. Эчнээ 3 жилийн сургалтад элсэгч алба хаагчдыг элсэлтийн шалгалтын суурь болон хавсарга шалгалтын нийлбэр оноогоор буурах эрэмбээр жагсааж, хөтөлбөр тус бүрээр элсүүлэх хяналтын тоонд багтаан элсүүлнэ.

8.3. Бакалаврын хөтөлбөрийн 4 жилийн өдөр, 5 жилийн эчнээ сургалтад элсэгч алба хаагчдыг элсэлтийн ерөнхий шалгалтын чансааны онооны эрэмбээр жагсааж, хяналтын тоонд багтаан элсүүлнэ.

8.4. Алба хаагчдаас нэмэлт шалгалт авахгүй.

### **Ес. Элсүүлэх шийдвэр гаргах**

9.1. Комиссын хуралдаанаар элсэлтийн шалгалтын дүнг хэлэлцэн, шалгуур хангаж, шалгалтад тэнцсэн элсэгчийг сонгосон хөтөлбөрт элсүүлэн суралцуулах саналыг Их сургуулийн захиралд танилцуулна.

9.2. Бакалаврын хөтөлбөрт элсүүлэн суралцуулах тухай Комиссын саналыг үндэслэн Их сургуулийн захирал тушаал гаргана.

9.3. Алба хаагчдыг элсүүлэн суралцуулах тухай тушаалыг 2018 оны 07 дугаар сарын 20-ны дотор, иргэдийг элсүүлэн суралцуулах тухай тушаалыг 2018 оны 08 дугаар сарын 25-ны дотор гаргаж, захиалагч агентлаг, байгууллагад мэдэгдэнэ.

### **Арав. Элсэлтийн шалгалтын комиссын эрх, үүрэг**

10.1. Элсэлтийн шалгалтыг Элсэлтийн шалгалтын комисс /цаашид “Комисс” гэх/ зохион байгуулна. Комиссын бүрэлдэхүүнийг захиалагч агентлаг, байгууллагын төлөөллийг оролцуулан Их сургуулийн захирлын тушаалаар батална.


10.2. Комисс болон комиссын дарга Их сургуулийн захирлын 2014 оны Б/286 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “ХСИС-ийн элсэлтийн шалгалт зохион байгуулах нийтлэг журам”-д заасан чиг үүрэг, бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

### **Арван нэг. Бусад зүйл**

11.1. Элсэгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч элсэлтийн шалгалтын үйл явц, комиссын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлоо Их сургуулийн захиралд хандан гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй.

ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛЬ

Хууль сахиулахын их сургуулийн захирлын  
2018 оны . . . дугаар тушаалын хоёрдугаар  
хавсралт



ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН 2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН  
ЖИЛД ЭЛСЭЛТ АВАХ БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨР, ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТЫН  
БОСГО ОНОО, ХЯНАЛТЫН ТОО

№	Хөтөлбөрийн нэр, индекс		Элсүүлэх хяналтын тоо, хүйс		Шалгалтын чиглэл, босго оноо	
			Нийт	Үүнээс: Сонгон шалгаруулалтаар	Суурь	Хавсарга
<b>Өдрийн сургалт</b>						
1	“Цагдаа- хууль сахиулах ажил” /D103201/ 2.5(2)1.5 жил		120	Эрэгтэй-90	Нийгмийн тухай мэдлэг <u>Босго оноо:</u> 580	Математик Гадаад хэл <u>Босго оноо</u> <u>тус бүр:</u> 480
2	“Хилийн алба” D103802 /4 жил/	Эрх зүй	18	Элсэгч-10 Алба хаагч-5	Нийгмийн тухай мэдлэг <u>Босго оноо:</u> 480	Математик Гадаад хэл <u>Босго оноо</u> <u>тус бүр:</u> 400
3		Тусгай бэлтгэл	18	Элсэгч-10 Алба хаагч-5	Нийгмийн тухай мэдлэг <u>Босго оноо:</u> 480	Математик Гадаад хэл <u>Босго оноо</u> <u>тус бүр:</u> 400
4	Шүүхийн шинжилгээ-хууль сахиулах ажил D103204 /4 жил/		18	Эрэгтэй-15	Математик <u>Босго оноо:</u> 560	Нийгмийн тухай мэдлэг Гадаад хэл <u>Босго оноо</u> <u>тус бүр:</u> 480
5	“Шалган нэвтрүүлэх алба- хууль сахиулах ажил” D103206 /4 жил/		30	Элсэгч-10 Алба хаагч-15	Нийгмийн тухай мэдлэг <u>Босго оноо:</u> 520	Математик, Гадаад хэл <u>Босго оноо</u> <u>тус бүр:</u> 480
6	“Цэргийн сэтгэл судлал” D031301 /4 жил/		18	Элсэгч-10 Алба хаагч-5	Нийгмийн тухай мэдлэг <u>Босго оноо:</u> 520	Математик, Гадаад хэл <u>Босго оноо</u> <u>тус бүр:</u> 480
7	“Шүүхийн шийдвэр гүйцэтгэл-хууль сахиулах ажил” D103202 /4 жил/		30	Эрэгтэй-25	Нийгмийн тухай мэдлэг <u>Босго оноо:</u> 520	Математик, Гадаад хэл <u>Босго оноо</u> <u>тус бүр:</u> 480
8	“Аюулгүй байдал- хууль сахиулах” D103801 /4 жил/	Аюулгүй байдал- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	25	Эрэгтэй-20	Нийгмийн тухай мэдлэг <u>Босго оноо:</u> 560	Математик, Гадаад хэл <u>Босго оноо</u> <u>тус бүр:</u> 480
9		Аюулгүй байдал- Дотоодын цэрэг	36	Эрэгтэй-30	Нийгмийн тухай мэдлэг <u>Босго оноо:</u> 560	Математик, Гадаад хэл <u>Босго оноо</u> <u>тус бүр:</u> 480

10	“Нийгмийн ажил” D092301 /4 жил/	12	Эрэгтэй-5 Эмэгтэй-5	Нийгмийн тухай мэдлэг <u>Босго оноо:</u> 560	Математик, Гадаад хэл <u>Босго оноо</u> <u>тус бүр:</u> 480
11	Онцгой байдал-гамшгаас хамгаалах алба D103205 /4 жил/	25	Эрэгтэй-16 Эмэгтэй-4	Математик <u>Босго оноо:</u> 560	Нийгмийн тухай мэдлэг Гадаад хэл <u>Босго оноо</u> <u>тус бүр:</u> 480
12	Эрх зүй D041201 /4 жил/	60	Хүйс харгалзахгүй-60	Нийгмийн тухай мэдлэг <u>Босго оноо:</u> 400	ЭЕШ өгсөн нэг хичээл Гадаад хэл <u>Босго оноо</u> <u>тус бүр:</u> 400
<b>Эцнээ сургалт</b>					
1	Цагдаа-хууль сахиулах ажил D103201	3 жил	Алба хаагч-30 (Дээд боловсролтой)	Эрх зүйн мэдлэг 60 хувь	Гадаад хэл 40 хувь
2		2 жил	Иргэн-30 (Дээд боловсролтой, эрэгтэй)	Өмнөх бакалаврын дипломын голч дүн 2.6-аас доошгүй	
3		Шинжээч- мөрдөгч 2 жил	Иргэн-30 (Дээд боловсролтой, эрэгтэй)	Өмнөх бакалаврын дипломын голч дүн 2.6-аас доошгүй	
4		5 жил	Алба хаагч-60 (Бүрэн дунд боловсролтой, эрэгтэй)	Элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн нэг хичээлийг сонгох <u>Босго оноо:</u> 400	
5	Хилийн алба D103802 /3 жил/		Алба хаагч-25 (Дээд боловсролтой)	Эрх зүйн мэдлэг 60 хувь	Гадаад хэл 40 хувь
6	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл- хууль сахиулах ажил D103202	3 жил	Алба хаагч-25 (Дээд боловсролтой)	Эрх зүйн мэдлэг 60 хувь	Гадаад хэл 40 хувь
7		5 жил	Алба хаагч-25 (Бүрэн дунд боловсролтой, эрэгтэй)	Элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн нэг хичээлийг сонгох <u>Босго оноо:</u> 400	
8	Онцгой байдал- гамшгаас хамгаалах алба D103205	5 жил	Алба хаагч-20 Эрэгтэй-16 Эмэгтэй-4 (Бүрэн дунд боловсролтой)	Элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн нэг хичээлийг сонгох <u>Босго оноо:</u> 400	
9		1.5 жил	Алба хаагч-18 (Тусгай дунд боловсролтой)	“Галын техникч” мэргэжлээр “С” дипломтой төгссөн алба хаагч	

## ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛЬ